

*Олон Улсын Мэдээлэл Түгээхүйн Академийн Монголын салбар,
МХСҮНийгэмлэгээс эрхлэн гаргадаг "Хил судлал"
сэтгүүлийн уншигчдад*

Хил судлалын шинжлэх ухааны тухайд

Баримтуудыг нэгтгэн дүгнэх, салангид таамаглалуудыг холбон уялдуулж онол боловсруулах шаардлагатй болсон үед нэг сэдэвт бүтээл хэмээх судалгааны төрлийг эрдэмтэд голчлон хэрэглэдгийг шинжлэх ухааны түүх гэрчилж байна.

Хил, хязгаар нутагт төр, нийгэм, оршин суугчдын ашиг сонирхол, улсын хил, эдийн засгийн онцгой бүсийг хамгаалах чиглэлээр хуримтлагдсан бүхийл мэдлэгийг нэгтгэж тодорхой тогтолцоо бүрдүүлэх цаг болсон гэж бид үзсэн юм.

Сүүлийн 10 жилд гарсан уурь шинжлэх ухааны амжилтууд, судалгааны анхдагч обьектод огтын хамааралгүй үзэгдлүүдийг ашиглах ирээдүйтэй шинжлэх ухааны шинэ салбаруудыг бий болголоо.

Орчин үеийн амьдралаас урган гарч байгаа нарийн төвөгтэй асуудлууд, тэр тусмаа цогц шийдэл шаардаж байгаа билээ.

Хил, хязгаарын хамгаалалтад хамааралтай яам, газруудыг хамтруулж, хил судлалын анхдугаар бага хурал хийсэн 1993 оноос хил, хязгаар нутагт төр, нийгэм оршин суугчдын ашиг сонирхлыг хангах, хамгаалах гэхчилэн нийгэм, улс төрийн тодорхой үзэгдлүүдийн шинж байдал, хууль, зүй тогтлуудыг судалдаг шинэ шинжлэх ухааныг томёолон □Хил судлал□ гэж нэрлэх болсон ба энэн хугацаанд хил судлалыг шинжлэх ухааны нь хувьд нийтээр хүлээн зөвшөөрсөн юм. (Хил судлал Оюуны бүтээлийн олон улсын бүртгэлийн танхимд бүртгэгдсэн. Бүртгэлийн дугаар EIW 0001175. 1995.12.06).

Хил судлал цэргийн шинжлэх ухааны олон онолуудаас сонгон шингээсээр аажмаар хэлбэржин, түүхийн урт удаан хугацаанд төлөвшин хөгжиж ирсэн билээ.

ХИЛ СУДЛАЛ

80-90 онуудад улсын хил, эдийн засгийн онцгой бүсийн хамгаалалтын тухай орчин үеийн шинжлэх ухааны мэдлэгийн салбар бие даан нэг талаас онолуудыг задлан шинжилж, өөрчлө сайжруулахад чиглэгдсэн, нөгөө талаас түүний гол санаа агуулгыг үндэслэн хөгжүүлэх хэрэглүүр, хүчирхэг түлхэц болсон хэлбэрүүд эрчимтэй үүсэн тогтох үе шатыг дамжив.

Олон улсын амьдрал, нийгмийн байдалд гарсан өөрчлөлтүүд, аюулгүй байдлын онол, онцгой бүсийн хамгаалалтын онол, хилийн цэргийн байгуулалт, хил хамгаалах байгууллагуудын алба – байлдааны үйл ажиллагааны бүх талын хангалтын онолыг хөгжүүлсэн хийгээд бусад орнуудын туршлага, шинжлэх ухаан техникийн дэвшлийн ололтыг ашигласан маань шинжлэх ухааны бие даасан салбар – хил судлалыг буй болгоход хүчтэй түлхэц өгсөн юм.

Хил судлал бол улсын хил, хязгаар нутагт аюулгүй байдлыг хангах мэт, нийгэм улс төрийн нарийн үзэгдлүүдийн шинж байдал, хууль, зүй тогтлуудын талаарх мэдлэгийн тогтолцоо юм.

Хил судлал, бусад шинжлэх ухаануудын нэгн адил хуримтлагдмал шинжийг агуулдаг бөгөөд одоогийн шатанд өөрийн өнгөрсөн бүхий л ололтууд (тэрчлэн бусад чиглэлийн шинжлэх ухаануудын)-аа нэгтгэн дүгнэж байна.

Хил судлал цэрэг, урлаг, техник, эдийн засаг, улс төр судлал, эрх зүйн бусад салбар шинжлэх ухааны мэдлэгийн огтолцол дээр орших агаад түүний цогц, хуримтлагдмал шинж чухам үүгээр илэрч байна.

Хил судлалыг нэгдмэл шинжлэх ухаан болгон бүрдүүлэхдээ бид системчлэн цомхотгох хандлага хэрэглэж байгаа юм.

Шинжлэх ухааны хөгжил, судалгаа шинжилгээ хийгдэх чиглэлийн сонголтыг тухайн шатанд төр улсын дотор бодитой оршин байгаа нийгэм, түүхийн болон материаллаг нөхцлөөс салангид авч үзэх боломж байхгүй.

Орост “өөрчлөлт” хийгдэх хугацаанд удирдлагын янз бүрийн түвшинд гаргасан хариуцлагатай шийдвэрүүдийн шинжлэх ухааны хангамжийн түвшин буурч, суурь ба хавсарга судалгааны оюуны болоод материаллаг бааз муудан, шинжлэх ухааны судалгаанууд хуучрах байдалтай болсон нь хүчний байгууллагуудын үйл ажиллагаанд сөрөг нөлөөлсөн юм.

Гэлээ ч гэсэн эрдэмтэн мэргэжилтнүүд эдний дотроос Олон Улсын Мэдээлэл Түгээхүйн Академийн хил судлалын салбарын (отделение погранологии) жинхэнэ болон сурвалжлагч гишүүд, ОХУ-ын ХХААкадемийн залуу судлаачид, оросын хил хязгаарын аюулгүй байдлыг хангах амин чухал асуудлыг шийдвэрлэх шинжлэх ухаанч эрлээ шамдан хийсээр байгаа билээ.

Ийм учраас МХСҮНийгэмлэгээс эрхлэн гаргаж байгаа “Хил судлал” сэтгүүл, шинжлэх ухаан – танин мэдэхүй, нийгэм улс төр, техник эдийн засаг, сургалт хүмүүжлийн ихээхэн ач холбогдолтой юм.

Хил судлал шинжлэх ухааныхаа хувьд төр, улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, бие даасан байдал, тусгаар тогтнол, хөгжил дэвшлийг хангагч төр, нийгмийн институтуудийн үйл ажиллагааны цогцолсон хураангуй төрийн хилийн бодлогын үндэс болж байна.

Бидний үзэж байгаагаар хил судлалын бүх бүрэлдэхүүн хэсгүүдийн онолыг тодорхойлж, бүтэцчилж, системчлэн нэгтгэсэн бүрэн ойлгомжтой мэдлэг хуримтлагдахын хэрээр шинжлэх ухааны улсын бүртгэлд оруулан, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, хил судлалаар мэргэшсэн судлаачид, хил судлалын шинжлэх ухааны докторуудыг бэлтгэх нөхцөл бүрдэж байна.

Хил судлал сэтгүүл энэ бодит үл явцыг хурдасгана гэж найдаж байна.

*Олон Улсын Мэдээлэл Түгээхүйн Академийн ОХУ-ын
Хил судлалын салбарын ерөнхийлөгч академич В.Дмитриев.*